

## Герман дахь Монгол судлал ба хэтийн төлөв

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн  
Орос судлалын секторын эрхлэгч,  
доктор (Sc.D) О.Батсайхан

Миний бие Герман улсын Эрдэмтэн солилцох сангийн шугамаар Берлины Хумболдтын Их сургуулийн Төв Ази судлалын хүрээлэн дээр 3 сарын хугацаагаар ажилласан бөгөөд энэ хугацаанд Герман улсын номын сан, холбооны архив, Хумболдтын их сургуулийн номын санд голчлон ажиллаж, өөрийн судалгааны сэдэв болон Монгол Германы харилцааны түүхэнд холбогдох баримт бичиг материал эрж сурвалжлан судалсан болно.

### Герман улсын номын сангийн тухайд

Герман улсын номын сан (Staatsbibliothek)-д 2004 оны 6 дугаар сарын байдлаар 7200 гаруй монгол ном байна. Монголын эдүгээгийн бүх хэвлэл байна. Тэр номын санд 30-аад жилийн өмнө Монголоос гарсан эдүгээ Германы иргэн Нэргүй гэж эмэгтэй ажиллах юм. Номын санч Нэргүй гуайн ярьснаар хэдийгээр би Германы иргэн болсон ч Монголынхоо төлөө гэсэн сэтгэлтэй, би ямар ч байсан энд байгаа үедээ Монголд гарч буй том, жижиг бүх номыг худалдаж авахыг хичээдэг, ингэж би ном захиалахдаа хэлдэг, хойч үе маань ирээд Монголын маань ийм их олон ном байна гээд үзвэл миний Монголоо гэсэн сэтгэлийн үр шим тэр болох байх гэж ярьж билээ. Тус номын санд Манай хүрээлэнгийн хэвлэл болон Олон улс судлал сэтгүүл байхгүй байсан бөгөөд би тэдгээр хүмүүст хэлж захиалахаар болсон.

Хумболдтын их сургуулийн номын санд монгол ном нилээд байна. Би эндхийн бүх Монголын түүх, соёлд хамаарах номыг гараараа үзсэн. Нийтдээ 2000 гаруй Монголын түүх, монгол хэл, уран зохиолын холбогдолтой ном байна. Герман, англи, орос, монгол хэл дээр байх юм. Энд тухайлбал, Чингисийн холбогдолтой маш олон ном зохиол байна. Үнэндээ бид Чингис судлалаар баруунаас маш хол хоцорсон байна.

Олон улсын харилцааны түүхийн үүднээс Монгол улсын гадаад харилцааны түүхэнд холбогдох нилээд олон ном байна. Алис

Кампийн АНУ, Гадаад Монголын улс төрийн харилцаа 1915-1927 диссертаци, Лан Мэй Хуа-гийн диссертаци, Дэ вангийн тухай "Сүүлчийн монгол гүн", Урадын Е Булагийн The Mongols at China's Edge (2002 он, АНУ) сонирхолтой ном англи хэл дээр буй.

Германы Улсын үндэсний архивт ажиллалаа. Би архивт олон жил ажиллаж, архивт дасал болсон тул тэнд сайхан сэтгэгдэл төрсөн. Энэ бол олон улсын харилцааны баялаг өв сантай баян архив байх бөгөөд зөвхөн Монголын түүхэнд холбогдох олон шинэ материал үзэж судаллаа. Хятадад сууж байсан Германы элчин сайдын яам болон Новониколаевскт байсан консулын газраас Монголын хүн ам, нийгмийн байдал, газар нутаг, гадаад, дотоод харилцааны талаар удаа дараа ирүүлсэн мэдээ, мэдээлэлүүд Монголын түүх, Монголын олон улсын харилцааны зарим асуудал, Монгол-Германы харилцааны түүхийг судлахад чухал хэрэглэгдхүүн болох юм.

Германд 1920-иод оны Монголын газрын зургийг Монгол Улсын Ардыг гэгээрүүлэх яамны захиалгаар өнгөтөөр хэвлэсэн нь маш сайн хадгалагдсан байна. Эл газрын зургийг Герман дахь Монголын Элчин сайдын яаманд хэлж, хувилуулж авахуулсан болно.

Германы Хумболдтын Их сургуулийн Төв Азийн Монгол судлалын төв дээр ажилласан бөгөөд энд монгол судлаач эрдэмтэн профессор Ута Шёне гуай ажиллаж байна. Тус төвд одоогоор 30 гаруй герман оюутан, магистр, докторант суралцаж байна. Ихэвчлэн угсаатан судлал болон монголын бөө шашины зарим асуудлыг судалж байна.

Германд Монгол судлал ер уналтын байдалд байна гэхэд болохоор байна. Хуучнаар Баруун Герман болон Зүүн Герман аль алинд нь Монгол судлал төрөөс бага ивээгдэж байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд үүнийг монгол судлаач герман профессорууд нотлон ярьж байна. Тухайлбал Хумболдтын Их сургуулийн Монгол судлалын бие даасан чиглэл үгүй болж, монгол судлал Төв Ази судлалд орсон байна. Үүний улмаас өмнө нь 10 профессорын орон тоотой байсан монгол судлалын төв одоо ганцхан профессорын орон тоотойгоор ажиллаж байна.

1941 онд Дэлхийн хоёрдугаар дайны үед Германд төрсөн Ута Шёне гуай эдүгээ жар гарсан ч Хумболдтын Их сургуулийн Төв Ази судлалын Монгол судлал хариуцсан ганц профессор юм. 1960-аад оны эхээр тэрбээр олон хүний эсэргүүцлийг давж, өөрийн өвөөгийн дэмжлэгтэйгээр монгол судлалыг сонгож авсан байна. Шёне

багшийн өвөө нь Сибирийн өмнөх нутгаар нэгэнтээ аялж байсан хийгээд тэр үедээ монгол хүмүүс их сайхан сэтгэлтэй болохыг олж мэдсэн тул түүнийг ийм сонголт хийхэд эерэг хандсан хүн ажээ. Ута Шёне гуай анх 1964 оны 9 сард БНАГУ-ын Хумболдтын их сургуулийн Монгол хэлний ангийн гурван оюутан (Ренате Бауве мөн нэг эрэгтэй оюутан) Монголд анх удаа соёлын солилцооны гэрээгээр иржээ. Түүнээс хойш 40 жил өнгөрсөн хэдий ч Шёне багш монгол хэлээр гайхалтай яруу сайхнаар, элдэв гадаадын үг хэллэг холихгүй ярьдаг нь бидэнд сургамжтай санагдсан болно. Тэрбээр надад "түүнээс хойш манай оюутнууд тасралтгүй Монголд очиж байгаа. Яг одоо нэг оюутан Улаанбаатарт буй. Монгол Улсын Их Сургуульд сурч буй. Зарим оюутан Ховдын салбарт очиж суралцаж, үүнд бид их баярлаж байгаа" хэмээн хуучилсан юм.

Германд Монгол судлал бүр 19 дүгээр зууны сүүл, 20 дугаар зууны эхээр Хятад судлалын тэнхмийн нэг хэсэг болж үүссэн байна. Берлины Фридрих Вилгельмийн их сургууль дээр анх Монгол судлалын суурь тавигджээ. Бүр 1832 онд Германы алдарт аялагч, газар зүйч Хумболдт Хятад болон Монголын говиор аялаад Монголын тухай дурьдахдаа "Энэ бол ирээдүйд судалвал зохих сул орон зай" мөн хэмээн бичсэн байх бөгөөд үнэхээр ч Хумболдтын хэлсэнчлэн бүр тэр үеэс Монголыг германчууд сонирхон судалж байсныг архивын олон эх сурвалж нотлон харуулж байна. Профессор Ута Шёнегийн ярьсанчлан Герман дахь Монгол судлал эхэн үедээ 1945 он хүртэл гол дуу хэл судлалын чиглэлээр хөгжиж, улмаар дорно дахины судлалын нэг судалгааны предмет болж байжээ. Энэ үед хятад болон монгол судлаач Эриш Хайниш ажиллаж багшилж байсан бөгөөд эл хүн хятад бичгээс Монголын нууц товчоог герман хэлнээ 1930-аад онд орчуулсан байна. Харин уг зохиол герман хэл дээр дэлхийн хоёрдугаар дайны дараа нийтлэгдсэн байна.

1920-иод оны дунд үеэс Германд очиж байсан Ишдорж гуай Герман дахь Монгол судлал түлхүү хөгжихөд зохих нөлөө үзүүлсэн бололтой байна. Тэрбээр Германы гадаадынханд зориулсан дээд сургуульд суралцаж байсан Д.Нацагдорж, Пагмадулам, Бат Очир, Далай, Санжаа нарын монгол хүүхдүүдийг хариуцаж байсан бөгөөд үүний зэрэгцээ Германы Их дээд сургуулийн Монгол судлалын хэлтэстэй холбоотой байж, эрдэмтэн Хайниш гуайд Монголын газрын зургийг бэлэглэж байсан удаатай ажээ.

1954 онд Проф. Рачневскийг хятад судлал, монгол судлалын профессор болгосон байна. Тэрбээр Юань улсын түүхийг судалдаг байжээ. Энэ үеэс Герман дахь Монгол судлалын нэгэн шинэ үе эхэлж, Монгол судлал хятад судлалаас салж, бие даасан салбар болон хөгжжээ. Өөрөөр хэлбэл хавсарга чиглэл бус, монгол судлал гэсэн бие даасан чиглэлээр оюутан сургаж эхэлсэн байна.

Энэ үйл явдал нь БНМАУ БНАГУ-тай дипломат харилцаа тогтоосонтой шууд холбоотой байв. 1960 аад оноос эхлэн Герман дахь Монгол судлал маш их өргөжсөн бөгөөд яг энэ үеэр Монгол судлалыг өөрийн амьдралын утга учир болгож сонгож авсан герман хүмүүсийн нэгэн бол Ута Шёне гуай юм. Энэ бол Зүүн Герман дахь монгол судлалын асуудал билээ. Зүүн Германы Монгол судлалыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн бол 1970 аад оны хоёрдугаар хагасаас Хумболдтын Их сургуулийн Монгол судлалыг тэргүүлж байсан профессор Ханс Петер Фийце гуай ажээ. Түүний удирдлага дор 35 мянган үгтэй Герман Монгол хэлний хамгийн анхных болох толь бичиг 1981 онд анх хэвлэгдэж, түүнд Монголын Академич Ц.Дамдинсүрэн, доктор Гэндэнгийн Лувсан болон доктор Габрилле Наги нар оролцсон байна. Энэхүү өргөн хэрэгцээний Герман Монгол толь бичиг гурван удаа дахин хэвлэгдсэн байна. Үүний дараа Монгол Герман толь бичиг мөн л Проф. Ханс Петер Фийце гуайн удирдлага дор Клаус Коппе, Габриеле Наги, Түмэнбаярын Дашцэдэн нар зохиож 1988 онд хэвлэжээ. Энэхүү хамтын бүтээл нь Берлиний Хумболдтын нэрэмжит Их Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн эрдэмтдийн хамтын ажиллагааны үр дүнд буй болсон хэмээн Толь бичгийн өмнөх үгэнд дурьджээ. Эдгээр Герман-Монгол, Монгол-Герман толь бичгүүдийг Герман, Австри, Швейцарь зэрэг орны дэлхийн герман хэлтэй хүмүүс өргөн ашиглаж байна. Дээрх толь бичгийг бүтээхэд зохиогчдоос гадна эрдэмтэн Х.Цойнер, Т.Дашцэдэн, Удо Баркман, А.Гюнтер, К.Коппе, К.Кёрнер, У.Хаазе, Б.Кайзер, О.Оберхак, Ш.Чоймаа, Р.Бауве, У.Шёне нар оролцсон байна.

Үүний дараа Германы Хумболдтын Их сургуулийн Монгол судлалын төв Монгол Улсын Их Сургуультай хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулж, 1967 оноос хойш 1990 оны 1 дүгээр хагас хүртэл тасралтгүй Монгол Улсын Их Сургуулиас монгол хэлний багш нарыг урин ирүүлж багшлуулдаг байжээ. Үүнд, Монголоос ирж ажиллаж байсан багш нар гэвэл проф. Дашцэдэн, Ш.Чоймаа,

Г.Лувсан нарын зэрэг эрдэмтэд ажээ. Монголын эдгээр эрдэмтэд Германы монгол хэлийг сонирхон сурч байсан хүмүүст ихээхэн ач тусаа өгч, тэдний хэлний мэдлэгийг дээшлүүлж, монгол соёлтой танилцахад дөхөм болгожээ. Хумболдтын Их сургууль Монгол Улсын Их Сургууль одоо хүртэл хоорондоо ийм хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байгаа ажээ. Монгол судлал, нийгмийн ухааны чиглэлээр Монголын их сургуультай холбоо тогтоосон Германы анхны их сургууль бол Хумболдтын их сургууль ажээ.

Дээр дурьдсан хоёр сургуулийн хамтын ажиллагааны гэрээний дагуу герман хэл дээр проф. Дашцэдэнгийн Монгол бичгийн сурах бичиг, Чоймаа, Р.Бауве нарын Халх хэлний фонетикийн дасгал (хэлний дадлага хийх кассет бүхий) номуудыг хийж хэвлэн сургалтандаа ашиглаж буй ажээ.

Ийнхүү Германы Хумболдтын Их сургуулийн Монгол судлалын нэг томоохон ололт бол монгол хэлтэй мэргэжилтэн бэлтгэх явдал байсан бөгөөд энэ үүргээ хангалттай сайн биелүүлж байсан учраас Германы Гадаад яам болон Монгол дахь Германы Элчин сайдын яам, хийгээд Монгол дахь Олон улсын байгууллагуудад одоо хүртэл монгол хэлтэй мэргэжилтнүүд ажилласаар байна. Мэдээж энэ бүхэнд Герман улсын төрөөс Монгол судлал хийгээд Монгол Германы харилцаанд багагүй ач холбогдол өгч анхаарч байсаны илрэл буй за хэмээн бодож байна.

Харин сүүлийн жилүүдэд 1990 ээд оноос хойш Герман дахь Монгол судлалын байдал эрс өөрчлөгдөж, зарим талаар уналтанд орсон байна. 1994 онд 9 профессор багшийн орон тоотой байсан Хумболдтын нэрэмжит их сургуулийн Монгол судлал 1996 онд 4, 1999 оноос 1 багшийн орон тоотой болтлоо буурчээ. Энэ хугацаанд 10-аад оюутан Монгол судлалаар магистр, 1 хүн докторын диссертаци бичиж хамгаалсан байна.

1999 оны зуны семестрээс тус сургуулийн монгол судлалын чиглэл хумигдаж (учир нь ганцхан профессортой) Төв Ази судлал дотор монгол судлал багтах болсоор эдүгээ хүрчээ. Уг нь Монгол судлалын чиглэлээр болон монгол хэлийг сонирхон судлагчид бас цөөнгүй байгаа нь 2004 оны 6 сарын байдлаар харахад тэнд пав 30 гаруй оюутан, магистр, докторант суралцаж буйгаас тод харагдана. Мэдээжийн хэрэг Төв Азийн олон орноос Монголыг сонгон авч оруулан судалж байгаа нь сайн хэрэг боловч урьдын байсан түвшингээс нилээд дор орсон болохыг бас харж болох

юм. Тус сургуулийн Монгол судлалд Герман оюутнуудаас гадна Польш, Австри, Швейцарь, Турк, Солонгос, Англи, Голланд, Бельги зэрэг гадаадын орнуудаас ирж суралцаж байсан байна. Эдүгээ ч бас Итали, Франц, Польш зэрэг орнуудаас сургалтанд хамрагдаж байгаа нь тун бахархууштай хэрэг. Герман улсын Монгол судлалын сургалт, судалгааны бааз нь нилээд сайнаас гадна дэлхий нийтэд таньж мэдэгдсэн нэр хүнд бүхий сургууль дээр төвлөрсөн явдал юм. Монгол улсын төр хийгээд монгол судлалыг хөгжүүлэн дэмжигч хэн боловч Герман дахь Монгол судлалыг өргөжүүлэх улмаар Европ дахь Монгол судлалын төв хэвээр дэлгэрэн хөгжөөсэй хэмээн үнэн санаагаар хүсэж байна. Германы эрдэмтэд маань өөр өөрсдийн шугамаар Монгол судлалын бодит байдлаа танилцуулж, хөгжүүлэхийг эрмэлзэж буйд талархахын ялдамд монголчууд бидний зүгээс тус дэм үзүүлэх явдал чухал хэмээн санана.

Хумболдийн Их сургуулийн Төв Ази судлалын Монгол судлалын профессор Ута Шёне гуай "миний бодоход Япон, Хятад, Өмнөд Солонгос зэрэг оронд Монгол судлалын бие даасан төв байна. Тэдгээр улс орон Монголд их анхаарал тавьж буй. Тэд боловсон хүчин бэлдэж байна. Үүнийг Герман улс сайн бодохгүй байна" хэмээн ярив. Шёне багш "Монголын түүх, Монгол хэлний зүй, Орчин цагийн Монгол хэл, Орос, Хятад дахь Монголчууд, Монгол бичиг гэх зэргээр бүхий л хичээлийг ганц биендээ үүрч яваа" тухайгаа өгүүлээд "намайг 2 жилийн дараа тэтгэвэртээ суухаар Монгол судлалын хувь заяа маань хаашаа эргэх бол хэмээн санаа нь зовнингүй суусныг өгүүлэх юун.

Мөн түүнчлэн проф. Ханс Петер Фийце монгол судлалын талаар өгүүлэхдээ эдүгээ Хумболдтын их сургуулийн Монгол судлал 1 хүний орон тоотой байгаа цаашдаа дор хаяад 4 юмуу 5 хүний орон тоотой болбол нэн сайнсан гээд "Ах дүү орон байсан үед ч гэсэн одоо ч гэсэн монгол судлал шинжлэх ухааны бодлоготой их холбоотой байв. Монголын түүх, соёл, хэл бүгдийг нэг хэлтэс хариуцаж байсан нь Монголын талаар нэгдсэн дүгнэлт хийхэд дөхөмтэй байсан юм. Орчин цагийн монгол хэлэнд их анхаарал хандуулдаг байсны улмаас Монголд ажилладаг, монгол хэл мэддэг герман хүн бүхэн Хумболдтын их сургуулиас төрсөн байв. 1990 ээд он гэхэд барууныхан Монголыг бага мэддэг байсан, харин 1996 оноос хойш Герман-Монголын харилцаа өргөжиж, хүрээгээ тэлж эхэлж байна. Энэхүү хоёр улсын харилцааны нааштай байдал Герман дахь Монгол судлалд нааштайгаар нөлөөлөөсэй хэмээн бодож байна" гэж ярив.

Германы Хумболдтын Их сургуулийн Монгол судлалын чиглэл бие даасан чиглэл байхад хамгийн сүүлд төгссөн азтан бол Инес Столпи хэмээх бүсгүй юм. Тэрээр ярихдаа "Манай профессор Ута Шёне өдөр шөнөгүй хичээл заадаг. Түүнд эрдэм шинжилгээний ажил хийх зав байхгүй" хэмээн өгүүлээд харин манай сургуульд монгол судлалаар суралцах оюутны хувьд олон байгаа. Одоо Германаас Монголд ирж суралцдаг оюутны тоо цөөн байна, миний дараа бараг хэн ч яваагүй, ядаж 1 семестр Монголд байхгүй бол хэл сурахгүй шүү дээ хэмээлээ.

Бид уулзсан багш нараасаа Монголын талаас ямар дэмжлэг үзүүлж болох бол хэмээн сонирхоход уг нь монгол багш нар явуулбал сайн гэж бодож байна хэмээн ярилаа. Дээр нь бид ер нь Монголд юу болж байгаа талаар хангалттай мэдээлэл авдаггүй, сонин хэвлэл бага байна гэж өгүүлэв.

Энэ бүгд бол Германы Хумболдтын нэрэмжит их сургуулийн монгол судлаач багш нарын яриа болон Германд монгол хэлтэй оюутан бэлтгэж ирсэн баялаг туршлага, өв сан, түүнд тулгуурласан санал төлөв билээ.

Харин Монголын түүх, хэл, соёлтой нягт холбоо бүхий суурь судалгаа хийж ирсэн төв бол Германы Бонн хотын их сургууль бөгөөд тэнд нэрт монгол судлаач, эрдэмтэн профессор Вальтер Хайссиг гуайн удирдлага дор монгол судлал тун эрчимтэй хөгжиж ирсэн байна. В.Хайссиг гуай Монголын түүх, соёл, хэл зохиолын талаар өөрийн нягт нямбай судалгаа хийхийн зэрэгцээ профессор К.Загастер, М.Вайерс, В.Файт нарын зэрэг олон авьяаслаг монголч эрдэмтийг төрүүлэн гаргасан байна. Монголчуудын түүх, хэл соёл, үндэсний өвөрмөц зан заншлын талаар Герман эрдэмтэд маань маш олон тооны үнэт бүтээлүүд туурвиж, монголчуудын түүхийн талаар дэлхий дахинаа таниулахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулж байгаа нь үнэн билээ. Миний бие энэ бэсрэг өгүүлэлдээ Баруун Германы (хуучин нэрээр) эдгээр эрдэмтдийн бүтээл туурвилын талаар дэлгэрэнгүй эс өгүүлэв учир нь монгол хэлнээ эрдэмтэн С.Алимаа, Г.Лувсан нарын Германы Монголч эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалт хэмээх товхимол монгол хэлнээ гарсан бөгөөд түүнд ХБНГУ дахь монгол судлалын талаар нилээд дэлгэрэнгүй өгүүлсэн буй. Түүнчлэн Эрдэмтэн Вальтер Хайссиг гуайн бичиж нийтлүүлсэн "Германы их дээд сургуулиудад эрхэлж буй монгол судлал" 1969 онд герман хэл дээр гарсан бол Михаэл Вайерсийн "Төв Азийн Хэл соёл судлалын

семинар” 1998 онд, Вероника Файтын “Райны Фридрих Вилхельмийн нэрэмжит Бонны их сургуулийн Төв Азийн хэл соёл судлалын семинар” 1998 он зэрэг ном товхимол өгүүллүүд Герман дахь монгол судлалын талаар хэвлэгдсэн байна.

Цаашид ХБНГУ дахь Бонн хотын их сургуулийн проф. М.Вайерсийн удирдсан Монгол судлалын төв, Хумболдтын Их сургуулийн проф. Ута Шёнегийн удирдсан Монгол судлалын төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж, урамшуулах нь зүйтэй мэт санагдсаныг өгүүлэх юун. Герман дахь Монгол судлалын эцэг нь яах аргагүй нэрт эрдэмтэн проф. В.Хайссиг гуай бөгөөд түүний үйл ажиллагааг өвлөн авсан хүн бол проф. К.Загастер нар мөн билээ. Харин монгол хэлтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын ажиллагааг дөч гаруй жил дагнаж ирсэн монголч эрдэмтэн проф.Ута Шёне гуай болон тус сургуулийн Монгол судлалын төвийнхөнд талархал илэрхийлэх нь зүйтэй болов уу.

Эдүгээ дээрх монголч эрдэмтийн залгамж халаа болж, Германы Монгол судлалын хүнд ачааг нуруундаа үүрч яваа эрдэмтэдийн нэг бол яах аргагүй Удо Б. Баркманн билээ.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн хувьд Германы сургалт, судалгааны олон байгууллагатай харилцдаг байх гэхдээ Герман дахь Монгол судлалын талаар дорвитой үйл ажиллагаа явуулж хамтын ажлын санаачлагыг гартаа авч өрнүүлэх нь зүйтэй мэт санагдсаныг уламжлах байна.

Германы архив, номын санд Монголчуудын түүхтэй холбоотой олон сонирхолтой эх сурвалж, ном буй бөгөөд тэр бүгдийг судалгааны эргэлтэнд оруулбал монгол судлалд өөрийн хувь нэмрээ оруулна хэмээн бодож байна.

Герман улс бол оюуны нөөц бололцоогоо дайчилж, хүний оюуны чадавхийг өндөр үнэлдэг нь харагдаж байсан, бидэнд тэндээс суралцах, шууд аваад хэрэглэж болохоор тийм зүйлс их байсныг хэлэх байна. Манай ШУА-ийн удирдлагад Германд дээд сургууль дүүргэсэн эрдэмтэд ажиллаж байгаа нь сайн хэрэг бөгөөд харин Монголынхоо шинжлэх ухааныг дорвитой хөгжүүлэх талаар өөрийнхөө санал бодлыг зоригтой уралдуулж хэрэгжүүлээсэй хэмээн хүсмээр байна.